

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ  
ХУВЬЦААТ КОМПАНИ

**ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

**Тендер шалгаруулалтын нэр:** Эрүүл мэндийн үзлэг хийх гүйцэтгэгчийг сонгон  
шалгаруулах тендер

**Тендер шалгаруулалтын дугаар:** ХАН<sup>№</sup>19/14

**Хаяг:** Улаанбаатар хот Багануур дүүрэг  
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”  
ТӨХК-ийн конторын байр.

**Утас:** 99020551, 99665151  
**Факс:** 70210167

## ХАН№19/14 тоот тендерийн урилга

Эрүүл мэндийн үзлэг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

**Хаяг:** Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

**Утас:** 99665151, 99020551

**Факс:** 70210167

## Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан цахим хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдоод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/
4. **Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. **Алдааг залруулах**
  - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
    - (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;

- (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар.</li> <li>2. Үнийн санал. /<b>маягтын дагуу</b>/</li> <li>3. Сүүлийн нэг жилийн буюу 2018 оны санхүүгийн тайлан. /Аудитлагдсан тайлан байна/</li> <li>4. Тухайн аж ахуйн нэгж шүүхийн ямар нэгэн маргаанд хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт.</li> <li>5. ШШГЕГ-ын шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт. /Шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байх/</li> <li>6. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /<b>Татварын тодорхойлолтыг <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайтын лавлагааг үндэслэнэ</b>/</li> <li>7. Тендерийн баримт бичгийг цахимаар авна.</li> <li>8. Сүүлийн 1 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт ирүүлнэ. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>9. Эмнэлгийн үйл ажиллагаа эрхэлж буй компанийн танилцуулга, тоног төхөөрөмжийн жагсаалт дэлгэрэнгүй танилцуулга тус тус ирүүлнэ.</li> <li>10. Үзлэг шинжилгээ хийх хугацааны график баталгаажуулан ирүүлнэ.</li> <li>11. Эрүүл мэндийн үзлэг хийж дууссаны дараа ажилтнуудын лаборатори шинжилгээ, дотор ЭХО, рентген шинжилгээний хариу болон Ерөнхий эмчийн дүгнэлт тус бүрийг PDF файл болгон CD хэлбэрээр захиалагч байгууллагын эмчид хүргүүлэхэд татгалзах зүйлгүй талаарх мэдэгдэл ирүүлнэ.</li> <li>12. Ажилчдын мэргэжлийн ур чадварын тодорхойлолт, нарийн мэргэжлийн эмч нарийн эмчлэх эрхийн лицензийн хуулбар хувийг ирүүлнэ.</li> <li>13. Тендерийн төсөвт өртөг НӨАТ тооцсон дүн болохыг анхаарна уу.</li> <li>14. НӨАТ-ын гэрчилгээний хуулбар, НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх.</li> </ol> <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p><b>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн байр, 2-р давхар 202 тоот өрөө Утас:99665151</b></p>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p><b>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</b> Энэхүү тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p><b>Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутад.</b></p>
<b>ТӨӨЗ 2.2</b>	<p>Тендерийн нээлт хийх хугацаа нь:</p> <p><b>Цахим тендерийн нээлтийг 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 30 минутад цахим системээр нээнэ.</b></p>
<b>ТӨӨЗ 7.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><b>Багцгүй</b></p>

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ ЯВУУЛАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эрүүл мэндийн үзлэгийг хийхдээ дараах үзлэг шинжилгээний шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

1. Нарийн мэргэжлийн ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн эмч мэргэжилтнүүдтэй байх, эмч нар нь тухайн мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан байх.
2. Урьдчилан сэргийлэх үзлэг хийх багаж тоног төхөөрөмжөөр хангагдсан байх. /ЭХО, Рентген, Дуран, ЭКГ гэх мэт/ Хавсралтад заасан шаардлагыг хангасан байх.
3. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулж байсан туршлагатай байх./Эрүүл мэндийн үзлэгийг орон нутагт хийх нөхцөлд/
4. Шинжилгээг тухайн эмнэлэгийн лаборатори хариуцан ажилтан нь үзлэгт орж байгаа ажилтнуудын ажлын байранд өөрийн унаагаар ирж сорьц, шинжилгээний дээж авах ажлыг зохион байгуулах.
5. Ажилтны овог нэр, нас, лабораторийн шинжилгээний хариуг үнэн зөв гаргаж, гарсан гомдол саналыг шийдвэрлэх боломжтой байх.
6. Нарийн мэргэжлийн эмч нар нь тухайн мэргэжлийн чиглэлээр 5-с доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх.
7. Шаардлагатай тохиолдолд нийт ажилтнуудад онош тодруулах, нарийн үзлэг, шинжилгээ, зөвлөгөө өгөх, зөвшөөрөл ирүүлэх./Ходоодны дуран, зүрхний ЭХО, тархины судасны бичлэг гэх мэт /
8. Эрүүл мэндийн үзлэгийг хуваарийн дагуу хугацаанд нь чанартай сайн үзэж ажилтан тус бүрээр Ерөнхий эмчийн эрүүл мэндийн дүгнэлт гаргуулах.
9. Хэвтэн эмчлүүлэх шаардлагатай байгаа ажилтныг хэвтэн эмчлүүлэх боломжоор хангах, зардлыг ажилтан өөрөө хариуцна.
10. Эрүүл мэндийн үзлэг дууссаны дараа ажилтнуудын лаборатори шинжилгээ, дотор ЭХО, рентген шинжилгээний хариу болон Ерөнхий эмчийн дүгнэлт тус бүрийг файлаар болон CD хэлбэрээр захиалагч байгууллагын эмчид хүргүүлэх.
11. Үзлэг хийх өрөө кабинетийг дугаарлах, ажилтан үзүүлэх маршрут гаргах, үзлэгийн тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагаа бэлэн байдлыг хангаж ажиллах бүрэн боломжтой байх./Улаанбаатар хотод үзлэг хийгдэх нөхцөлд/
12. ЭМС-ын 2014 оны 340 дүгээр тушаалаар баталсан “Ажил мэргэжлээс хамааран эрүүл мэндийн үзлэг хийх жагсаалт”-ын дагуу нийт ажилтнуудын 20 хувьд нэмэлтээр үзлэг хийх боломжтой байх.

1. Нарийн мэргэжлийн эмч нарын багийн бүрэлдэхүүнд:

дд	Мэргэжил	Ажилласан жил	Ажиллах эмчийн тоо
1	Зөвлөх эмч буюу ерөнхий эмч	10-аас доошгүй	1
2	Дотор	5-аас доошгүй	1
3	Зүрх судас	5-аас доошгүй	1
4	Бөөр	5-аас доошгүй	1
5	Дотоод шүүрэл	5-аас доошгүй	1
6	Чих хамар хоолой	5-аас доошгүй	1
7	Харшил,хордлого/мэргэжлээс шалтгаалах мэргэжлийн эмч/	5-аас доошгүй	1
8	Мэдрэл	5-аас доошгүй	1
9	Эмэгтэйчүүд	5-аас доошгүй	1
10	Нүд	5-аас доошгүй	1

2. Багажийн шинжилгээ:

№	Багажны шинжилгээ	Ашиглах аппарат	Хамрагдах хүний тоо
1	Зүрхний цахилгаан бичлэг	1	516
2	Цээж гэрэлд харах	1	516
3	ЭХО/Дотор, эмэгтэйчүүд, түрүү булчирхай, зүрхний/	1	516
4	Ходоодны дуран, зүрхний ЭХО	1	100-аас багагүй хүн
5	Сонсгол шалгах	1	516
6	Хараа шалгах, нүдний уг дурандах, харааны талбай тодорхойлох, харааны өнгө шалгах	1	516

3. Лаборатори шинжилгээ:

3.1 Шээсний ерөнхий шинжилгээ

3.2 Цусны ерөнхий шинжилгээ

3.3 Эмэгтэйчүүд

- Мазок
- Эсийн шинжилгээ

3.4 Биохимийн шинжилгээ

№	Шинжилгээний төрөл	Үзүүлэлт	Хамрагдах хүний тоо
1	Шээсний ерөнхий шинжилгээ	Бөөрний үйл ажиллагааны өөрчлөлт	516
2	Цусны ерөнхий шинжилгээ	Цус багадалт, биеийн үйл ажиллагааны өөрчлөлт	516
3	Мазок шинжилгээ	Эмэгтэйчүүдийн үтрээний цэвэршилт, үрэвсэл	167
	Эсийн шинжилгээ	Хавдрын урьдал өвчин илрүүлэх	167

№	Биохимийн шинжилгээ		Хамрагдах ажилтны тоо
1	Билирубин	Элэгний үйл ажиллагаа	516
2	Альбумин		
3	ГОТ/АСАТ/		
4	ГПТ/АЛАТ/		
5	Шүлтлэг фосфотаз	Цөсний үйл ажиллагаа	516
6	Амилаз	Нойр булчирхайн үйл ажиллагаа	516
7	Сахар	Дотоод шүүрэл	516
8	Холестрин	Зүрхний үйл ажиллагаа	516
9	Триглицерид		
10	LDL, HDL		
11	Креатинин	Бөөрний үйл ажиллагаа	516
12	Мочевин		
13	Үлдэгдэл азот		

№	Иммунологийн шинжилгээ		Хамрагдах хүний тоо
1	ASLO	Үе мөчний шинжилгээ	516
2	CRP		
3	RF		
4	H-pylori	Хелико бактери илрүүлэх	516
5	В вирус маркер эсвэл чанарын шинжилгээ	Элэгний вирус илрүүлэх	516
6	С вирус маркер эсвэл чанарын шинжилгээ	Элэгний вирус илрүүлэх	516



3.5 Нэмэлтээр: Витамин Д, Хавдрын маркер, Эрдэсүүд/Кали, Кальци, Магни гэх мэт/ санал болгосноор шинжилгээ хийх боломжтой байх. /Зардлыг ажилтан өөрөө хариуцна/

4. Эмнэлэгийн тоног төхөөрөмж:

№	Үзлэгт ашиглах аппарат		Хамрагдах хүний тоо
1	Бүрэн автомат ЭХО аппарат /Улаанбаатар хотын үзлэгт/	Дотор эрхтэн, элэг цөс, бөөр, дэлүү, нойр булчирхайн бүтэц, эмэгтэйчүүд болон түрүү булчирхайн үйл ажиллагааны өөрчлөлт	516
2	Хагас автомат ЭХО аппарат /Орон нутагт/		
3	Дурангийн аппарат	Улаан хоолой, ходоодны үйл ажиллагааны өөрчлөлт	516
4	Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат	Зүрхний үйл ажиллагааны өөрчлөлт	516
5	Рентген аппарат	Сүрьеэ өвчин илрүүлэх, Зүрх уушигны үйл ажиллагааны өөрчлөлт	516
6	Оношлуур лабораторын аппаратууд	Цус, шээсний шинжилгээнд гарах өөрчлөлтүүд	516

Үзлэгт ашиглах аппарат тоног төхөөрөмжүүд нь:

1. Рентген оношлогооны аппарат ашиглах, хадгалах тусгай зөвшөөрөлтэй байх.
2. Цөмийн болон цацрагийн аюулгүйн үнэлгээний дүгнэлт гаргуулсан байх.
3. Ионжуулагч цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах эрхийн зөвшөөрөлтэй байх.
4. Үзлэгт ашиглах аппаратууд нь доорхи аппаратуудын үзүүлэлттэй дүйцэхүйц байх.

#### 4.1 ХЭТ АВИА ОНОШЛОГООНЫ АППАРАТ / СУУРИН /

№	Асуумж	Тоног төхөөрөмж
1	Үйлдвэрлэгч	Medison
2	Марк модель	AY-MNT-15ТТК- аппараттай дүйцэхүйц

Шалгалт тохируулгын үр дүн:

№	Шалгалт тохируулга хийсэн үзүүлэлт	Хэмжих утга	Хэмжилтийн утга	Дээд хязгаар	Доод хязгаар	Хэмжих нэгж	
1	Гадна байдлын үзлэг	Тоног төхөөрөмжийн цэвэр аритгагдсан байдал хангагдсан байна.					
		Их бие, дэлгэц, суурь болон бүтээгдэхүүн хэсгүүд гэмтэлгүй байна.					
		Удирдлагын товчлуур болон унтраалга бүрэн ажиллагаатай байна.					
		Тэжээлийн залгуур адаптер бүрэн гэмтэлгүй байна.					
		Датчик цэвэр гэмтэлгүй байна.					
2	Гүнийн нэвчилт	190	200	210	170	mm	
		Босоо чиглэлийн хэмжилт	5	5.5	5.5	4.5	mm
			4	4.1	4.5	3.5	mm
	3		3.1	3.5	2.5	mm	
	Цацрагалтын хэмжилт	2	2.5	2.5	1.5	mm	
		Хэвтээ чиглэлийн хэмжилт	5	5.3	5.5	4.5	mm
			4	4.4	4.5	3.5	mm
			3	3	3.5	2.5	mm
	Голомтын дүрслэл	Фантомын голомтын дүрслэлийг сарнилгүй зөв бүртгэн авч байсан					
	3	Дохиолол	+				

#### 4.2 ХЭТ АВИА ОНОШЛОГОО / ЗӨӨВРИЙН /

№	Асуумж	Тоног төхөөрөмж
1	Үйлдвэрлэгч	Medison
2	Марк, модель	ACCUVIXEX-DOM- аппараттай дүйцэхүйц

Шалгалт тохируулгын үр дүн:

№	Шалгалт тохируулга хийсэн үзүүлэлт	Хэмжих утга	Хэмжилтийн утга	Дээд хязгаар	Доод хязгаар	Хэмжих нэгж
	Гадна байдлын	Тоног төхөөрөмжийн цэвэр ариутгагдсан байдал хангагдсан байх				
		Их бие, дэлгэц, суурь болон бүтээгдэхүүн хэсгүүд гэмтэлгүй байна.				

1	Үзүүлэлт		Удирдлагын товчлуур болон унтраалга бүрэн ажиллагаатай байна.					
			Тэжээлийн залгуур адаптер бүрэн гэмтэлгүй байна					
			Датчик цэвэр гэмтэлгүй байна.					
2	Цацаргалтын хэмжилт	Гүнийн нэвчилт	190	200	210	170	mm	
		Босоо чиглэлийн хэмжилт	5	5	5.5	4.5	mm	
			4	4.5	4.5	3.5	mm	
			3	3.3	3.5	2.5	mm	
			2	2.5	2.5	1.5	mm	
		Хэвтээ чиглэлийн хэмжилт	5	5.5	5.5	4.5	mm	
			4	4.2	4.5	3.5	mm	
			3	3.5	3.5	2.5	mm	
		Голомтын дүрслэл		Фантомын голомтын дүрслэлийг сарнилгүй зөв бүртгэн авч байсан				
		3	Дохиолол		+			

#### 4.3 ДУРАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

№	Шинжилгээ	Үзүүлэлт	Хамрагдах хүний тоо
1	Улаан хоолой, ходоодны дуран шинжилгээ	Онош тодруулах зорилгоор	Онош тодруулах шаардлагатай хүнд хийх

#### 4.4 ЗҮРХНИЙ ЦАХИЛГААН БИЧЛЭГИЙН АППАРАТ

№	Асуумж	Тоног төхөөрөмж
1	Үйлдвэрлэгч	New Tech Medical Limited ECG 1501-аппараттай дүйцэхүйц
2	Марк модель	

Шалгалт тохируулгын үр дүн:

№	Шалгалт тохируулга хийсэн үзүүлэлт	Хэмжих утга	Хэмжилтийн утга	Дээд хязгаар	Доод хязгаар	Хэмжих нэгж	
1	Гадна байдлын үзлэг	Тоног төхөөрмжийн цэвэр, ариутгагдсан байдал хангагдсан					
		Их бие, дэлгэц, суурь болон бүтээгдэхүүн хэсгүүд гэмтэлгүй байна.					
		Датчик болон дагалдах хэрэслүүд гэмтэлгүй байна					
		Удирдлагын товчлуур болон унтраалга бүрэн ажиллагаатай байна.					
		Тэжээлийн залгуур болон адаптер бүрэн гэмтэлгүй байна.					
		Батарейн ажиллагаа хэвийн байх					
2	Зүрхний цохилт	30	30	32	28	bpm	
		60	60	63	57	bpm	
		80	80	84	76	bpm	
		100	100	105	95	bpm	
		120	120	126	114	bpm	
		150	150	63	57	bpm	
		170	170	179	161	bpm	
3	Долгионы хэлбэр	R wave detection	30	30	32	28	bpm
		QRS detecision	120	120	126	114	bpm
		T Tall wave rejection	80	80	84	76	bpm
4	Хэм алдагдал	Nomal sinus rhythm	60	60	63	57	bpm
		Supraventricular	Симулятороос өгсөн дохиог зөв хүлээн авч байсан				
		Premature					
		Ventricular					
		Conduction					
		TV Paced					
		ACLS					
5	Амплитуд	10	10.5	10.5	9.5	mm	
	Хэвлэх хурд	25	26	26	24	mm/sek	
	Цаасны зогсолт	+					
	Дохиолол	+					

#### 4.5 РЕНТГЕН ОНОШЛОГООНЫ АППАРАТ

№	Асуумж	Тоног төхөөрөмж
1	Үйлдвэрлэгч	SHIMADZU
2	Марк модель	Xsy Pro- аппараттай дүйцэхүйц
3	Хүчин чадал	40 kv, 125 ma

Шалгалт тохируулгын үр дүн:

№	Шалгалт тохируулга хийсэн үзүүлэлт	Хэмжих утга	Хэмжилтийн утга	Дээд хязгаар	Доод хязгаар	Хэмжих нэгж
1	Гадна байдлын үзүүлэлт	Тоног төхөөрөмжийн цэвэр ариутгагдсан байдал хангагдсан байх				
		Их бие, дэлгэц, суурь болон бүтээгдэхүүн хэсгүүд гэмтэлгүй байна.				
		Удирдлагын товчлуур болон унтраалга бүрэн ажиллагаатай байна.				
		Тэжээлийн залгуур адаптер бүрэн гэмтэлгүй байна				
		Датчик цэвэр гэмтэлгүй байна.				
2	Цацаргалтын хэмжилт	Гүнийн нэвчилт	Цөмийн энергийн тухай хууль, Цацрагийн аюулгүйн норм болон бусад дүрмийн шаардлагыг хангасан ионжуулагч цацрагийн үүсгүүрийг ашиглах, хадгалах эрхийн зөвшөөрөлтэй байна.			
		Босоо чиглэлийн хэмжилт				
		Хэвтээ чиглэлийн хэмжилт				
	Голомтын дүрслэл					

#### 4.6 ЛАБОРАТОРЫН ШИНЖИЛГЭЭ

№	Лабораторын тоног төхөөрөмжийн нэр	Тавигдах шаардлага
1	PCR- шинжилгээний аппарат /DNA technology DT Prime 4/	Бүрэн автомат HUMAR STAR-100 багажтай дүйцэхүйц
2	Биохимийн шинжилгээний аппарат /А-6/	
3	Иммунологийн шинжилгээний аппарат HumaRedar Single plus	

	HUMAN	
4	MAGLUMI /Snibe/ /Иммунологийн бүрэн автомат/	
5	Цусны ерөнхий шинжилгээний аппарат HumaCount 30 <sup>ts</sup> HUMAN	

Шалгалт тохируулгын үр дүн:

№	Шалгалт тохируулга хийсэн үзүүлэлт	Хэмжих утга	Хэмжилтийн утга	Дээд хязгаар	Доод хязгаар	Хэмжих нэгж
1	Гадна байдлын үзүүлэлт	Тоног төхөөрөмжийн цэвэр ариутгагдсан байдал хангагдсан байх				
		Их бие, дэлгэц, суурь болон бүтээгдэхүүн хэсгүүд гэмтэлгүй байна.				
		Удирдлагын товчлуур болон унтраалга бүрэн ажиллагаатай байна.				
		Тэжээлийн залгуур адаптер бүрэн гэмтэлгүй байна				
		Датчик цэвэр гэмтэлгүй байна.				
2		Шинжилгээнд ашиглах аппарат нь мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт гаргуулсан байх.				

## Эрүүл мэндийн үзлэгт хамрагдах ажиллагсдын бүсийн байршил хамрагдах хүний тоо

№	Салбар	Байршил	Нийт ажилтны тоо	2019 онд шинээр ажилд орсон	Захиргааны чөлөөтэй	Хамрагдвал зохих	эр	эм
1	Төв компани	Багануур дүүрэг	98	2	3	96	58	35
2	Багануур ЦТСС	Багануур дүүрэг	79	1		78	54	24
3	Хэнтий ЦТСС	Хэнтий аймаг	110	3	0	107	72	35
4	Дорноговь ЦТСС	Дорноговь аймаг	85	2		83	56	27
5	Говьсүмбэр ЦТСС	Говьсүмбэр аймаг	85	3	0	82	50	32
6	Дундговь ЦТСС	Дундговь аймаг	73	3		70	56	14
Нийт			530	14	3	516	349	167

Жич: Тендерт оролцогч нь техникийн тодорхойлолтын дагуу үзлэг шинжилгээг хийх төлөвлөгөөг гаргахдаа хөдөө орон нутагт байрлах салбар компаниудын ажилчдын үзлэгийг очиж газар дээр нь хийх эсвэл өөрийн эмнэлэгт хуваарийн дагуу хийх эсэхээ тодорхой заана.

1. Орон нутагт очиж үзлэг шинжилгээ хийх санал ирүүлэх бол үзлэг шинжилгээ хийх дэлгэрэнгүй хуваарь, зөөврийн тоног төхөөрөмжийн жагсаалт, тухайн багаж төхөөрөмжийн тодорхойлолт зэргийг ирүүлнэ. Мөн бүх эмч нарын байр, хоол, унааны зардал зэргийг үнийн саналдаа багтаан ирүүлнэ.
2. Тендерт оролцогч өөрийн эмнэлэг дээр үзлэг шинжилгээ хийх санал ирүүлэх бол үзлэг шинжилгээ хийх дэлгэрэнгүй хуваарь, суурин багаж тоног төхөөрөмжийн жагсаалт, тухайн багаж төхөөрөмжийн тодорхойлолт зэргийг ирүүлнэ. Мөн үзлэгт хамрагдах ажилчдын ирэх буцах тээврийн зардлыг үнийн саналдаа багтаан ирүүлнэ.

## Долоо. **ЖИШИГ МАЯГТ**

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны .... дүгээр сарын .....-ны өдөр

**БЗӨБЦТС ТӨХК**-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]*, *[гэрээний нэр ба дугаар]*-ыг *[тендерийн үнийг тоогоор болон үсгээр]* төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. **Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх** 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгэнэ.
2. **Төслийн менежерийн шийдвэр** 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.
3. **Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх** 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.
4. **Аюулгүй байдал** 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.  
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.
5. **Зааварчилгаа** 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй
6. **Маргааныг шийдвэрлэх** 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

7. **Ажлын хөтөлбөр** 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.  
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.
8. **Зөрчил, гологдол илрүүлэх** 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.
9. **Зөрчил, гологдол арилгахгүй байх** 9.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 10. Ажил дуусгах** 10.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавина.
- 11. Эцсийн тооцоо** 11.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж төслийн менежерт хүргүүлнэ.
- 12. Гэрээг цуцлах** 12.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 12.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
  - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
  - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
  - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
  - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 13. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр** 13.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 13.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.